


# ЗҮҮН ӨМНӨД АЗИД ХУДАЛДААЛАГДДАГ ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМЛЫН ЗҮЙЛИЙГ ТАНИХ ГАРЫН АВЛАГА

Монгол улсын зохих хууль  
тогтоомжоос оруулсан болно.



# Гарчиг (1)

Энэхүү гарын авлагыг Зүүн Өмнөд Азийн TRAFFIC (Зэрлэг амьтдын худалдаа мониторингийн сүлжээ)-аас хууль сахиулах албаны ажилтан, албан хаагч нарт Зүүн Өмнөд Азийн улс орнуудад түгээмэл худалдаалдаг зэрлэг амьтан, ургамлын зүйлийг танихад зориулан 2008-2013 оны хооронд бэлтгэсэн ба **103** хуудастай.

## ЭХ ҮҮСВЭР

Зэрлэг Амьтан ба Ургамлын Аймгийн Ховордсон Зүйлийг Олон Улсын Хэмжээнд Худалдаалах Тухай Конвенц (CITES) *цаашид САЙТИС гэж оруулав*  
Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны (IUCN) Улаан данс *цаашид ДБХХ-ны Улаан данс гэж оруулав*  
САЙТИС-ийн Удирдах зөвлөл болон Шинжлэх Ухааны Зөвлөл  
САЙТИС-ийн Зөвшөөрлийг Баталгаажуулах гарын авлага  
Хэмжилтууд болон тайлбар толь  
Хууль бусаар бараа нэвтрүүлдэг түгээмэл аргууд – Хүний биед  
Хууль бусаар бараа нэвтрүүлдэг түгээмэл аргууд – Ачаанд болон гар тээшинд нуух  
Хууль бусаар бараа нэвтрүүлдэг түгээмэл аргууд – Ачаанд нуух  
Хууль бусаар бараа нэвтрүүлдэг түгээмэл аргууд – Төстэй зүйлийн амьтадтай хамт  
Хууль бусаар бараа нэвтрүүлдэг түгээмэл аргууд – Тэжээвэр, үржүүлгийн амьтан нэрийдлээр  
Хуурамч зөвшөөрлийг илрүүлэх  
Хуурамч зөвшөөрлүүд илэрдэг түгээмэл тохиолдлууд

## ХӨХТӨН АМЬТАД

<i>Bos gaurus &amp; Bos javanicus</i>	Энэтхэгийн Бизон үхэр болон Бантенг үхэр (Gaur and Banteng)
<i>Capricornis</i>	Хөхвөр гөрөөс (Serows)
<i>Pantholops hodgsonii</i>	Түвд гөрөөс (Tibetan Antelope - Shatoosh)
<i>Saiga tatarica</i>	Монгол бөхөн (Saiga Antelope)
Deer and Antlers	Буга болон бусад эвэрт амьтад (Multi-tined Antlers)
<i>Moschus spp.</i>	Хүдэр (Баданга хүдэр) (Musk Deer)
<i>Felidae</i> (1)	Мийн овог (Cats)
<i>Felidae</i> (2)	Мийн овог – САЙТИС I хавсралтад бүртгэгдсэн Зүүн Өмнөд Азийн мийн овгийнхон (Southeast Asian CITES I Cats)
<i>Felidae</i> (3)	Мийн овог Түгээмэл худалдаалагддаг дайвар эрхтнүүд болон тэдгээрийн хэсэг (Cat parts & derivatives commonly found in trade)
Southeast Asian Otters.	Зүүн Өмнөд Азийн халиу (Southeast Asian Otters)
<i>Helarctos malayanus</i>	Наран баавгай (Sun Bear)
<i>Ursus thibetanus</i>	Азийн Хар баавгай (Asiatic Black Bear)
<i>Hemigalus derbyanus &amp; Chrotogale owstoni</i>	Судалт сивет ба Овстоны сивет (Banded Palm Civet & Owston's Civet)
<i>Prionodon pardicolor &amp; Prionodon linsang</i>	Толбот линсан (Spotted Linsang & Banded Linsang)
<i>Arctictis binturong</i>	Баавгай муур (Binturong)
Rhinocerotidae	Хирсний овог (Хирс) (Rhinoceros)
<i>Manis</i>	Шоргоолж идэштэн (Pangolins)
Primates	Мичний овог (Мичнүүд) (Primates)
<i>Nycticebus</i>	Лорис сармагчиний зүйлүүд (Lorises)
<i>Macaca fascicularis</i>	Урт суулт макак (Long-tailed Macaque)
<i>Elephas maximus &amp; Loxodonta africana</i>	Азийн ба Африкийн заан (Elephants)

Тус гарын авлагад агуулагдсан бүх зүйл амьтныг дараах хуулиар зохицуулна.  
Үүнд:

- Амьтны тухай, 2012
- Байгалийн ургамлын тухай, 1995
- Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, 2002
- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, 2002

Түүнчлэн САЙТИС-ийн хавсралтад бүртгэгдсэн болон бусад амьтан, ургамлын худалдаа, ашиглалтыг холбогдох журмын хүрээнд буюу “Амьтныг амьдаар нь болон амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах журам”, 2013, “Харь амьтны ашиглах журам” 2013 журмуудын хүрээнд шийдвэрлэнэ.

## ШУВУУД

<i>Dendrocygna javanica &amp; D. arcuata</i>	Исгэрэгч болон тэнүүлч нугас (Lesser & Wandering Whistling Ducks)
<i>Leptoptilos</i>	Бахлуурт өрөвтас (Adjutant Storks)
Bucerotidiformes.	Эвэр хошуут (Hornbills)
<i>Copsychus malbaricus</i>	Цагаан ууцат намнаахай (White-rumped Shama)
Falconiformes	Махчин шувууд (Birds of Prey)
<i>Pycnonotus zeylanicus</i>	Сүрлэн толгойт алтан гургалдай (Straw-headed Bulbul)
<i>Gracula religiosa</i>	Довын үглээ (Hill Mynah)
Psittaciformes	Тоть (Parrots)
<i>Cacatua</i>	Цагаан тодь (White Cockatoos)
<i>Probosciger aterrimus</i>	Сарвуу тодь (Palm Cockatoo)
<i>Eos</i>	Индонезийн тодь (Indonesian Lorikeets)
<i>Loriculus galgulus</i>	Хөх зулайт тодь (Blue-crowned Hanging Parrot)
<i>Lorius garrulus</i>	Шулганаа тодь (Chattering Lory)
<i>Lorius lory</i>	Хар малгайт тодь (Black-capped Lory)
Strigiformes	Ууль (Owls)

Англи хэлнээс орчуулсан: Бадамжавын Лхагвасүрэн, Биологийн ухааны доктор  
Лхагвасүрэнгийн Мягмаржав, АНУ-ын Вермонтын Их сургуулийн магистрант

Дэлхийн байгаль хамгаалах сан(WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас  
нэмэн засварласан хэвлэлт 2014 он



# Гарчиг (2)

## МӨЛХӨГЧИД

<i>Crocodylia</i>	Матар болон түүний арьс (Hides (Crocodile Hides))
Alligators & Caiman	Гүмбэрваа болон Кайман матар (Alligators & Caimans)
<i>Crocodylus novaeguinea</i> & <i>C. mindorensis</i>	Филлипин болон Шинэ Гвинейн матар (Philippine & New Guinea Crocodiles)
<i>Crocodylus porosus</i> & <i>C. siamensis</i>	Сиамын болон голын матар (Estuarine & Siamese Crocodiles)
<i>Tomistoma schlegelii</i>	Хуурамч гүмбэрваа матар (False Gharial)
<i>Uromastyx</i>	Өргөсөн сүүлт гүрвэл (Spiny-tailed Lizards)
<i>Phelsuma</i>	Өдрийн геккон гүрвэл (Day Geckos)
<i>Gekko gekko</i>	Модны геккон гүрвэл (Tokay Gecko)
<i>Varanus</i>	Хянуур варан гүрвэл (Monitor Lizards)
<i>Ptyas mucosus</i>	Дорнын харх могой (Oriental Rat Snake)
<i>Ophiophagus hannah</i> , <i>Naja</i>	Наж могой (Cobras)
Pythons	Аварга могой (Pythons)
<i>Morelia viridis</i>	Модны ногоон аварга могой (Green Tree Python)
<i>Carettochelys insculpta</i>	Гахай хамарт яст мэлхий (Pig-nosed Turtle)
<i>Chelus fimbriatus</i>	Матамата яст мэлхий (Matamata Turtle)
Cheloniidae and Dermochelyidae	Далайн яст мэлхий (Marine Turtles)
<i>Eretmochelys imbricata</i>	Харцага хошуут яст мэлхий (Hawksbill Turtle)
<i>Batagur</i>	Голын яст мэлхийн зүйлүүд (River Terrapins)
<i>Geoclemys hamiltonii</i>	Цөөрмийн хар яст мэлхий (Black Pond Turtle)
<i>Heosemys grandis</i>	Азийн цөөрмийн аварга яст мэлхий (Giant Asian Pond Turtle)
<i>Morenia ocellata</i>	Бирмийн нүдэн яст мэлхий (Burmese Eyed Turtle)
<i>Lissemys</i>	Хавхлага хуягт яст мэлхий (Flapshell Turtles)
<i>Cuora</i>	Азийн дөрвөлжин яст мэлхий (Asian Box Turtles)
<i>Leucocephalon yuwonoi</i>	Сулавесийн ойн яст мэлхий (Sulawesi Forest Turtle)
<i>Notochelys platynota</i>	Малайзын тэгш хавтаст яст мэлхий (Malayan Flat-shelled Turtle)
<i>Platysternon megacephalum</i>	Том толгойт яст мэлхий (Big-headed Turtle)
<i>Orlitia borneensis</i>	Малайзын аврага яст мэлхий (Malaysian Giant Turtle)
<i>Siebenrockiella leyensis</i>	Филлипиний ойн яст мэлхий (Philippine Forest Turtle)
<i>Trachemys scripta elegans</i>	Улаан чихт яст мэлхий (Red-eared Slider)
Testudinidae	Газрын яст мэлхий (Tortoises)
<i>Astrochelys (Geochelone) radiata</i>	Цацрагт Яст мэлхий (Radiated Tortoise)
<i>Astrochelys yniphora</i>	Мадагаскар арлын яст мэлхий (Ploughshare Tortoise)
<i>Chelonoides (Geochelone) carbonaria</i>	Улаан хөлт яст мэлхий (Red-footed Tortoise)
<i>Geochelone elegans</i>	Энэтхэгийн товруут яст мэлхий (Indian Star Tortoise)
<i>Geochelone platynota</i>	Бирмийн товруут яст мэлхий (Burmese Star Tortoise)
<i>Geochelone (Stigomochelys) pardalis</i>	Ирвэс яст мэлхий (Leopard Tortoise)
<i>Geochelone (Centrochelys) sulcata</i>	Африкын өргөст яст мэлхий African Spurred Tortoise
<i>Indotestudo elongata</i>	Шар толгойт яст мэлхий (Yellow-headed Tortoise)
<i>Malacochersus tornieri</i>	Хавтгай яст мэлхий (Pancake Tortoise)
<i>Manouria emys</i>	Азийн хүрэн яст мэлхий (Asian Brown Tortoise)
<i>Manouria impressa</i>	Өндөр уулын яст мэлхий (Impressed Tortoise)
<i>Amyda cartilaginea</i>	Азийн зөөлөн хуягт яст мэлхий (Asiatic Softshell Turtle)
<i>Chitra</i>	Зөөлөн хуягт нарийн толгойт яст мэлхий (Narrow-headed Softshell Turtle)
<i>Pelochelys</i>	Зөөлөн хуягт аварга яст мэлхий (Giant Softshell Turtle)
<i>Pelodiscus sinensis</i>	Хятадын зөөлөн хуягт яст мэлхий (Chinese Softshell Turtle)

## ХОЁР НУТАГТАН

*Dyscophus antongilii* \_\_\_\_\_ Лооль Мэлхий (Tomato Frog)

## ЗАГАС

*Scleropages formosus* \_\_\_\_\_ Азийн арована загас (Asian Arowana)  
*Cheilinus undulatus* \_\_\_\_\_ Наролеон загас (Humphead Wrasse)  
*Hippocampus* \_\_\_\_\_ Далайн морь (Seahorses)

## СЭЭР НУРУУГҮЙТЭН

*Tridacnidae* \_\_\_\_\_ Аварга хясаа (Giant Clams)

## УРГАМЛУУД

Nepenthaceae \_\_\_\_\_ Вааран ургамлууд (Pitcher Plants)  
Orchidaeceae (1) \_\_\_\_\_ САЙТИС I Хавсралтад бүртгэгдсэн  
Цахирмаа цэцэг (CITES Appendix I Orchids)  
Orchidaeceae (2) \_\_\_\_\_ Зэрлэг цахирмаа цэцгийг таних арга (Identification of Wild Orchids)  
*Gonystylus* spp. \_\_\_\_\_ Хатуу мод (Ramin)

# Зэрлэг Амьтан ба Ургамлын Аймгийн Ховордсон Зүйлийг Олон Улсын Хэмжээнд Худалдаалах Тухай Конвенц болон Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан данс

## Зэрлэг Амьтан ба Ургамлын Аймгийн Ховордсон Зүйлийг Олон Улсын Хэмжээнд Худалдаалах Тухай Конвенц

CITES буюу Зэрлэг Амьтан Ба Ургамлын Аймгийн Ховордсон Зүйлийг Олон Улсын Хэмжээнд Худалдаалах Тухай Конвенц (*цаашид САЙТИС гэж оруулав*) нь олон улсын гишүүн орнуудын засгийн газар хоорондын хэлэлцээр юм. Энэ нь зэрлэг амьтан ба ургамлын аль нэгэн зүйл (эсвэл тэдний эд эрхтэн, бүтээгдэхүүн гэх мэт ямар нэг хэсгээр нь хийсэн бүх зүйл) олон улсын худалдаанд хэт их хэмжээгээр ашиглагдаж, үүнээс шалтгаалан устах аюулд орохоос сэргийлэх, хамгаалах зорилготой.

Англи нэрийн товчлол буюу САЙТИС нэрээр олны танил болсон энэхүү Конвенцийн хүрээнд 30,000 гаруй зүйлийн амьтан ургамал багтсан байдаг. Эдгээрээс импортлох, экспортлох, дахин экспортлох, болон сэргээн нутагшуулахад тусгай зөвшөөрлийн бичгийн дагуу зөвшөөрөл авна. САЙТИС-ийн Конвенц нь 1, 2, 3 гэсэн дугаар бүхий Хавсралтуудтай бөгөөд зэрлэг амьтан, ургамлын худалдаалалт нь стандартчлагдсан зөвшөөрлийн дагуу маш өндөр хяналтан дор зохицуулагддаг гэдгийг илэрхийлнэ.

**I Хавсралт**-д устах аюулд орсон зүйлүүд ордог ба онцгой тохиолдолд л худалдаалахыг зөвшөөрдөг.

**II Хавсралт**-д хяналтгүй худалдаанаас болж аюулд өртөж болох зүйлүүд багтдаг. Энд устах аюулд орж болзошгүй зүйлүүд орно.

**III хавсралт**-д дор хаяж аль нэг оронд хамгаалагдсан ба бусад гишүүн орнуудын зүгээс худалдаанд нь хяналт тавих хүсэлт тавьсан зүйлүүд орно.

САЙТИС-ийн жагсаалтад орсон зүйлийн дээжийг зөвхөн шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн гааль/боомт дээр үзүүлсэн тохиолдолд гишүүн орноос импортлох эсвэл экспортлохыг зөвшөөрнө. Зарим тохиолдолд тухайн улсын хуулиар хязгаарлагддаг бөгөөд тухайн тохиолдолд тэрхүү хууль хүчин төгөлдөр байна. Нэмэлт мэдээллийг [www.cites.org](http://www.cites.org) хаягаар орж харна уу.

## Дэлхийн Байгаль хамгаалах Холбооны Улаан данс

IUCN буюу Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (ДБХХ) нь өөрийн нэгж байгууллага Зүйлийг хамгаалах зөвлөл (Species survival comission)-өөр дамжуулан 40 жилийн турш дэлхий даяар зүйл, дэд зүйл, биологийн олон янз байдал болон зарим популяцийн хамгааллын статусыг тодорхойлж аль нь устах аюулд орсныг анхаарсаар ирсэн.

ДБХХ-ны Улаан данс нь судлагдсан ургамал, амьтны ангилал зүй, хамгааллын статус, болон тархцын мэдээллээр хангадаг. Улаан дансны Ангилал болон Шалгуур нь устах аюулыг тодорхойлох үүрэгтэй.

**НХ (Нэн ховор)**, **Х (Ховор)** болон **ЭМ (Эмзэг)** гэсэн ангилалд орсон зүйлүүд **ӨБ (Өртөж болзошгүй)** эсвэл **ЭЛ (Элбэг)** гэсэн ангилалд орсон зүйлүүдээс илүүтэй дэлхийн хэмжээнд бүр мөсөн устаж үгүй болох эрсдэл ихтэй байдаг.

Нэмэлт мэдээллийг [www.redlist.org](http://www.redlist.org) хаягаар орж харна уу.

САЙТИС болон ДБХХ-ны Улаан дансны хооронд ямар нэг албан ёсны хамаарал байхгүй болно.

**САЙТИС** нь жагсаалтад орсон ургамал, амьтдыг олон улсад худалдаалахад ямар журам мөрдөхийг тодорхойлдог.

**ДБХХ-ны Улаан данс** нь амьтад болон ургамлын биологийн статусыг тодорхойлдог.



# САЙТИС-ийн Удирдах болон Шинжлэх Ухааны Зөвлөлүүд

САЙТИС нь тодорхой хэдэн зүйлүүдийг олон улсад худалдаалах асуудалд хяналт тавьдаг. Конвенцийн хүрээнд багтсан зүйлүүдээс импортлох, экспортлох, дахин экспортлох, болон шинээр нутагшуулахад тусгай зөвшөөрлийн бичгийн дагуу зөвшөөрөл авна. САЙТИС-ийн гишүүн орон болгон тэрхүү тусгай зөвшөөрлийг хянах нэг болон түүнээс дээш Удирдах Зөвлөл мөн тэдэнд зүйлийн худалдаалалт тухайн зүйлийн статуст хэрхэн нөлөөлөх тухай зөвлөгөө өгдөг нэг болон түүнээс дээш Шинжлэх Ухааны Зөвлөлтэй байх ёстой.

Монгол улс дахь САЙТИС-ийн мэдээллийг доорх хаягаар хандаж авна уу.

САЙТИС-ИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧ:

**Дочинбуу Энхбат**

Хүрээлэн Буй Орчин Байгалийн Нөөцийн Газар  
Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яам  
Засгийн газрын хоёрдугаар байр  
Нэгдсэн үндэстний гудамж  
Улаанбаатар - 210 646

Утас: +976 (51) 26 64 26

Факс +976 (51) 26 64 26

Цахим хаяг: [d\\_enkhbat@mne.gov.mn](mailto:d_enkhbat@mne.gov.mn)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

**Ёндон Онон**


Хүрээлэн Буй Орчин Байгалийн Нөөцийн Газар  
Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яам  
Засгийн газрын хоёрдугаар байр  
Нэгдсэн үндэстний гудамж  
Улаанбаатар - 210 646

Утас: +976 (51) 26 64 26

Факс +976 (51) 26 64 26

Цахим хаяг: [onon@mne.gov.mn](mailto:onon@mne.gov.mn)


# САЙТИС-ийн Зөвшөөрлийг Баталгаажуулах Тухай






# Хэмжилтүүд болон тайлбар толь

## Хэмжилтүүд



Биеийн уртыг хамрын үзүүрээс сүүлний үзүүр хүртэл авна.

Шувууг нуруугаар нь болгоомжтой хэвтүүлж хэмжинэ.



Зохиогч: Канадын Хүрээлэн Буй Орчин

### Хайрс:

Матрын арьсан дээр болон яст мэлхийн хуяган дээр байдаг гадаад эвэрлэг эсвэл ясан хавтгай бүрхүүл.

### Дээд хуяг:

Яст мэлхийн нуруун хэсгийг хамгаалж байдаг, хуягны дээд хэсэг. Ихэвчлэн хайрсаар болон зөөлөн арьсаар хучигдсан байдаг.

### Доод хуяг:

Яст мэлхийн хэвлийг хамгаалж байдаг, хуягны доод хэсэг.

# Хууль бусаар бараа нэвтрүүлдэг түгээмэл аргууд ХҮНИЙ БИЕД

Ихэвчлэн өндөр үнэтэй, чамин, эсвэл жижиг болон ховор бараа тээвэрлэхэд ашиглана  
Энэхүү бүх оролдлогуудыг Австралийн гааль дээр илрүүлсэн.



Хууль бусаар өндөг гаргах гэж энэхүү хантаазыг өмссөн зорчигчийг Австралийн гааль дээр илрүүлсэн.

Зургийг: Австралийн гааль



Зургийг: Австралийн гааль

Зорчигчийн биед нуусан шувууны өндөгнүүд

Дотуур хувцсанд нуусан шувууны өндөгнүүд



Зургийг: Австралийн гааль

Шувууны өндөг хууль бусаар тээвэрлэх зориулалттай хормогч



Зургийг: Австралийн гааль



Энэхүү зорчигч Австралийн гаалиар нэвтрэхэд ажилчид ус цалгих чимээ сонсжээ. Загас хууль бусаар тээвэрлэх зориулттай хийгдсэн хормогч.

Зургийг: Австралийн гааль

Энэ хантааз дотор могойг хууль бусаар тээвэрлэх гэж хийсэн байна.



Зургийг: Австралийн гааль



# Хууль бусаар бараа нэвтрүүлдэг түгээмэл аргууд ГАР ТЭЭШИНД

Ихэвчлэн өндөр үнэтэй, жижиг болон ховор бараа тээвэрлэхэд ашиглана



Зургийг: Тайландын гааль


Тайландын гааль дээр зорчигчийн  
тээшийг рентгенд харсан байдал



Энэтхэгийн товруут яст мэлхий (*Geochelone elegans*)  
**САЙТИС II Хавсралт**



Зургийг: Тайландын гааль



Зургийг: Тайландын гааль

Цүнхэн дотор  
саванд нуусан  
хатуу хайрст  
гүрвэлүүд



Зургийг: Тайландын гааль

Тайландын гааль дээр энэ  
цүнхнээс **САЙТИС-ийн II  
Хавсралтад** орсон Хамелеон  
болон Энэтхэгийн товруут  
яст мэлхийг илрүүлжээ.



Зургийг: Тайландын гааль



Зургийг: Тайландын гааль

Цацрагт яст мэлхий  
(*Astrochelys*)  
**САЙТИС I Хавсралт**



Зургийг: Үндэсний Цагдаагийн Алба, Герман

Хорт суман мэлхий  
(*Dendrobates* spp.)  
**САЙТИС II Хавсралт**  
зургийн аппаратны  
хальсны саванд нуусан.



Зургийг: Тайландын гааль



Зургийг: Австралийн гааль

Австралийн гааль  
дээр номны  
завсар нуусан  
геккон гүрвэл

# Хууль бусаар бараа нэвтрүүлдэг түгээмэл аргууд АЧААНД НУУХ

## Ихэвчлэн их хэмжээний зүйл тээвэрлэхэд хэрэглэгддэг



2007 онд Тайландын Эзэн хааны гааль энэхүү ачааны машиныг рентген туяагаар шалгасан байна.

Тээшинд нь амьд шоргоолж идэштэн нуусан байжээ. Жолооч нь шууд зугтсан байна.



Зургийг: Тайландын Эзэн Хааны Гааль

- Зэрлэг ан амьтдыг автобус, такси болон бусад тээврийн хэрэгсэлд нуун тээвэрлэдэг.
- Мөн зэрлэг ан амьтдыг тахиа, загас гэх мэт өөр амьтадтай хамт нуудаг.



- Зэрлэг амьтад хийсэн эдгээр хуванцар хайрцагнууд нь амьтдыг амьсгалуулах зориулалттай нүхнүүдтэй (ялангуяа дөрвөн буланд нь) байдаг байна. Дотор нь гоёлын загаснууд байгаа гэсэн хэдий ч гүрвэлүүд байсан байна. Учир нь гүрвэлд ноогдох татвар загасныхаас өндөр. Аквариумын наймаачид мөн мөлхөгчдөөр наймаа хийдэг.
- “Анхаар: Хортой могой”, “Аюултай ачаа” гэх мэт наалтууд нь гаалиар шалгалтгүй орох гэсэн оролдлого байж болно.

Хяналтын байцаагчид хэдэн ширхэг болон аль аль хайрцгыг шалгахаа сонгох хэрэгтэй.



Зургийг: Тайландын Эзэн Хааны Гааль

Тайландын Эзэн Хааны гаалийн ажилтнууд үржүүлгийн газраас ирсэн зөөлөн хуягт яст мэлхий гэсэн барааг шалгажээ. Хайрцагын дээд давхрагийн ёроолд нь хууль бусаар наж могой тээвэрлэж байжээ.



Зургийг: Тайландын Эзэн Хааны Гааль

Тайландын Эзэн Хааны гаалийн ажилтнууд үржүүлгийн газарт ургуулсан цахирмаа цэцэг гэсэн барааг шалгажээ. Иймэрхүү бараан дунд заримдаа зэрлэг цахирмаа цэцэг нуусан байдаг.



# Хууль бусаар бараа нэвтрүүлдэг түгээмэл аргууд ТӨСТЭЙ ЗҮЙЛИЙН АМЬТАДТАЙ ХАМТ

Иймэрхүү бараанд нэг болон олон зүйлийн амьтан хийсэн боловч бүгдийг нь мэдүүлээгүй байдаг.

## Мэдэгдэж буй жишээнүүд

Азийн зөөлөн хуягт яст мэлхий  
*Amyda cartilaginea*

**САЙТИС: II Хавсралт**



Хятадын зөөлөн хуягт яст мэлхий  
*Pelodiscus sinensis*

**САЙТИС-д бүртгэгдээгүй**



Шар залаат тоть  
*Cacatua sulphurea*

**САЙТИС: I Хавсралт**



Хүрэн залаат тоть  
*Cacatua galerita*

**САЙТИС: II Хавсралт**



Азийн арована загас  
*Scleropages formosus*

**САЙТИС: I Хавсралт**



Зургийг: Тан Хөөк Хул

Жардины арована загас  
*Scleropages jardini*

**САЙТИС-д бүртгэгдээгүй**



Зургийг: Тан Хөөк Хул

# Хууль бусаар бараа нэвтрүүлдэг түгээмэл аргууд ТЭЖЭЭВЭР, ҮРЖҮҮЛГИЙН АМЬТАН НЭРИЙДЛЭЭР

Тэжээвэр, үржүүлэг гэдэг нь амьтдыг хяналтан дор үржүүлэхийг хэлдэг ба хууль бусаар бараа тээвэрлэгчид зэрлэг амьтдыг ихэвчлэн үржүүлгийн гэж мэдэгддэг.

Зөвхөн САЙТИС-ийн Удирдах зөвлөлд бүртгэлтэй газарт үржүүлсэн зарим зүйлийг, жишээ нь Азийн арована загасыг худалдаж болдог байна.



**Зөвхөн дараах нөхцөлд Азийн арована загасыг худалдаалж болно:**

1. Үржүүлэгч нь САЙТИС-ийн удирдах зөвлөлд бүртгэлтэй.
2. Тус загасанд микрочип суулгасан.
3. Тухайн загас үржүүлгийн хоёр дахь эсвэл түүний дараачийн удам байх.

Тухайн улсын хуулиар хамгаалагдсан амьтдыг зэрлэг байгалиас барьсан хэдий ч мөн л үржүүлгийн гэж мэдэгддэг байна.

Мөлхөгчдийг зулзага байхад нь байгалиас барьж үржүүлгийн гэж мэдэгддэг байна.

Жишээ нь:

Шар залаат тоть  
*Cacatua sulphurea*  
**САЙТИС I Хавсралт**



Панголин буюу шоргоолж идэштэн  
*Manis spp*  
**САЙТИС II Хавсралт\*\***



Модны маргад варан гүрвэл  
*Varanus prasina*  
**САЙТИС II Хавсралт**



Азийн усны варан  
*Varanus salvator*  
**САЙТИС II Хавсралт**



Гахай хамарт яст мэлхий  
*Carettochelys insculpta*  
**САЙТИС II Хавсралт**



САЙТИС болон тухайн орны хууль тогтоомжийн дагуу үржүүлгийн газарт ашиглах гэж буй амьтдын зөвшөөрлийг авах ёстой ба энэ нь байгальд байгаа зүйлүүдийн байдалд аюул учруулахгүй байх ёстой.

Үржүүлгийн популяци нь өөрийгөө тогтвортой тэтгэх хангалттай тоо толгойтой байх ба САЙТИС-ийн болон тухайн улсын хууль тогтоомжийн дагуу байгалиас барьсан амьтныг тухайн үржүүлгийн сүрэгт нийлүүлж болох бөгөөд гагцхүү байгальд байгаа зүйлийн байдалд аюул учруулахгүй байх ёстой.

# Хуурамч зөвшөөрлийг илрүүлэх

## Хуурамч зөвшөөрлийг илрүүлэх түгээмэл аргууд

Дараах зүйлсийг шалгаж байна уу:

**Хуурамч зөвшөөрөл** – гэдэг нь дууриалгаж хийсэн зөвшөөрөл юм.


- |  |  |
|--|--|
| <ol style="list-style-type: none"> <li>1. Цаас нь хэвийн бус</li> <li>2. Тамга, лац эсвэл баталгаат тамга</li> </ol> | <p>Зузаан, бүтэц, эсвэл өнгө нь өөр<br/>Муухай бүдүүлгээр дууриасан (САЙТИС-ийн гишүүн орнуудын зөвшөөрлийн бичгийн загвар тухайн орны Удирдах зөвлөлд байх ёстой)</p> |
|--|--|

**Засвар хийсэн зөвшөөрөл** – зөвшөөрөл олгогдсны дараа өөрчлөлт хийсэн.

- |  |   |
|--|---|
| <ol style="list-style-type: none"> <li>1. Зөвшөөрөл нь фото хувиар</li> <li>2. Энгийн бус хувилсан</li> <li>3. Бэхний толботой</li> <li>4. Зөвшөөрөлд нэмэлт, хасалт хийсэн</li> </ol> | <p>Зөвшөөрлийн эх хувийг л хэрэглэдэг (фото хувийг зөвшөөрсөн тохиолдолд ашиглах бөгөөд энэ тохиолдолд эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамгатай байх ёстой)</p> <p>Бэхний өнгө өөрчлөгдсөн, тухайн баримтанд өөр өөр үсгийн хэвтэй</p> <p>Зөвшөөрлийг өөрчлөхийн тулд будаг шингэрүүлэгч байх магадлалтай, үүнийг илрүүлэхийн тулд гэрэлд харах хэрэгтэй</p> <p>Зөвшөөрлийг өөрчилсөн тохиолдолд хүчингүй. (Удирдлагийн ажилтан өөрчлөлтийг баталгаажуулсан тохиолдолд болно)</p> |
|--|---|

**Хүчингүй зөвшөөрөл**

- |  |   |
|--|---|
| <ol style="list-style-type: none"> <li>1. Хугацаа нь дууссан</li> <li>2. Тээвэрлэж буй бараа нь мэдэгдсэн бараанаас зөрөх</li> </ol> | <p>Хугацаа нь дууссан зөвшөөрөл ашигласан.<br/>Зөвшөөрөл авсан өдрөөс хугацаа дуусах хүртэл экспорт, дахин экспортлох тохиолдолд 6 сараас, импортын зөвшөөрөл болон гарал үүслийн анкетын хувьд 12 сараас хэтрэхгүй байх ёстой</p> <p>Тухайн үед тээвэрлэж буй бараа нь тайлбартай зөрөх (өөр зүйл, өөр тоотой, эсвэл өөр бүтээгдэхүүн)</p> |
|--|---|


 <b>CONVENTION ON INTERNATIONAL TRADE IN ENDANGERED SPECIES OF WILD FAUNA AND FLORA</b>		<b>PERMIT/CERTIFICATE No.</b> <input type="checkbox"/> EXPORT <input type="checkbox"/> RE-EXPORT <input type="checkbox"/> IMPORT		Original 2. Valid until											
3. Importer (name and address)		4. Exporter/re-exporter (name, address and country)													
3a. Country of import		Signature of the applicant													
5. Special conditions		6. Name, address, national seal/stamp and country of Management Authority													
<small>For live animals, this permit or certificate is only valid if the transport conditions conform to the Guidelines for Transport of Live Animals or, in the case of air transport, to the IATA Live Animals Regulations</small>															
5a. Purpose of the transaction (see reverse)		5b. Security stamp no.													
7/8. Scientific name (genus and species) and common name of animal or plant		9. Description of specimens including identifying marks or numbers (age/sex if live)		10. Appendix no. and source (see reverse)											
7/8.		9.		10.											
11. Quantity (including unit)		11a. Total exported/Quota													
11.		11a.													
A		12. Country of origin * Permit no. Date		12a. Country of last re-export Certificate no. Date											
7/8.		9.		10.											
12b. No of the operation ** or date of acquisition ***		12b.													
7/8.		9.		10.											
B		12. Country of origin * Permit no. Date		12a. Country of last re-export Certificate no. Date											
7/8.		9.		10.											
12b. No of the operation ** or date of acquisition ***		12b.													
7/8.		9.		10.											
C		12. Country of origin * Permit no. Date		12a. Country of last re-export Certificate no. Date											
7/8.		9.		10.											
12b. No of the operation ** or date of acquisition ***		12b.													
7/8.		9.		10.											
D		12. Country of origin * Permit no. Date		12a. Country of last re-export Certificate no. Date											
7/8.		9.		10.											
12b. No of the operation ** or date of acquisition ***		12b.													
7/8.		9.		10.											
* Country in which the specimens were taken from the wild, bred in captivity or artificially propagated (only in case of re-export) ** Only for specimens of Appendix I species bred in captivity or artificially propagated for commercial purposes *** For pre-Convention specimens															
13. This permit/certificate is issued by:															
_____ Place Date Security stamp, signature and official seal															
14. Export endorsement 15. Bill of Lading/Air waybill number															
<table border="1"> <tr> <th>Block</th> <th>Quantity</th> </tr> <tr> <td>A</td> <td></td> </tr> <tr> <td>B</td> <td></td> </tr> <tr> <td>C</td> <td></td> </tr> <tr> <td>D</td> <td></td> </tr> </table>						Block	Quantity	A		B		C		D	
Block	Quantity														
A															
B															
C															
D															
Port of export		Date		Signature Official stamp and title											

CITES PERMIT/CERTIFICATE No.





# Хуурамч зөвшөөрөл илрүүлдэг түгээмэл тохиолдлууд

## Хуурамч зөвшөөрлийг илрүүлэхдээ:

**Экспортлох** – Хүснэгт 12-ын  (зургаан талт дүрс) хэсэгт үзүүлсэн мэдээллийг шалга

1. Аль улсаас гаралтай
2. Экспортын зөвшөөрлийн тоо
3. Экспортын зөвшөөрөл олгосон огноо

**Дахин экспортлолт** – Хүснэгт 12а-ын  (од дүрс) хэсэгт үзүүлсэн мэдээллийг шалга

1. Хамгийн сүүлд дахин экспортолсон орон
2. Дахин экспортлох зөвшөөрөл эсвэл батламжийн тоо
3. Зөвшөөрөл олгосон огноо
4. Хүснэгт 12-ын  (зургаан талт дүрс) хэсгийг бөглөсөн эсэхийг мөн шалга

## Тээвэрлэлт

1. Зөвшөөрөл дээрх эцсийн цэг буюу очих газар нь тээвэрлэлтийн бичиг баримт дээр дурдсантай тохирч буй эсэхийг шалга
2. Хэрэв боломжтой бол, тээвэрлэж буй бараа зөвшөөрөл дээр дурьдсантай нийцэж буй эсэхийг шалга

## Цирк болон аялж буй үзүүлбэрүүд

1. Амьтан болгонд өөрийн гэсэн аялан явааг гэрчлэх гэрчилгээ, САЙТИС-ийн зөвшөөрөл эсвэл батламж байх ёстой
2. Амьтан болгоны им, тамга, тэмдэг зэрэг нь гэрчилгээ эсвэл батламжтай тохирч буй эсэхийг шалга
3. Амьтан бүрийг тээвэрлэх зохистой нөхцлийг бүрдүүлсэн эсэхийг шалгах
4. Аялж буй болон үзүүлэнгийн гэрчилгээ эсвэл батламж нь 3 жилийн хугацаанд хүчинтэй байдаг ба шалгалтын дараа эх хувилбарыг хадгалах шаардлагагүй. Гэрчилгээ/батламж нь олон удаагийн экспорт/импортлогдсоныг батлах хүснэгт бүхий үргэлжлэлтэй

## САЙТИС-ийн гишүүн бус орнуудад худалдаалах

1. Бараанд САЙТИС-ийн зөвшөөрөлд шаардагддагтай адил бичиг баримтуудыг бүрдүүлнэ

CITES CONVENTION ON INTERNATIONAL TRADE IN ENDANGERED SPECIES OF WILD FAUNA AND FLORA		PERMIT/CERTIFICATE No.		Original	
3. Importer (name and address)		<input type="checkbox"/> EXPORT <input type="checkbox"/> RE-EXPORT <input type="checkbox"/> IMPORT		2. Valid until	
3a. Country of import		4. Exporter/re-exporter (name, address and country)			
5. Special conditions		6. Name, address, national seal/stamp and country of Management Authority			
5a. Purpose of the transaction (see reverse)		5b. Security stamp no.			
7/8. Scientific name (genus and species) and common name of animal or plant		9. Description of specimens including identifying marks or numbers (age/sex if live)		10. Appendix no. and source (see reverse)	
11. Quantity (including unit)		11a. Total exported/Quota			
7/8.		9.		10.	
A 12. Country of origin * Permit no. Date		12a. Country of last re-export Certificate no. Date		12b. No of the operation ** or date of acquisition ***	
7/8.		9.		10.	
B 12. Country of origin * Permit no. Date		12a. Country of last re-export Certificate no. Date		12b. No of the operation ** or date of acquisition ***	
7/8.		9.		10.	
C 12. Country of origin * Permit no. Date		12a. Country of last re-export Certificate no. Date		12b. No of the operation ** or date of acquisition ***	
7/8.		9.		10.	
D 12. Country of origin * Permit no. Date		12a. Country of last re-export Certificate no. Date		12b. No of the operation ** or date of acquisition ***	
7/8.		9.		10.	
* Country in which the specimens were taken from the wild, bred in captivity or artificially propagated (only in case of re-export) ** Only for specimens of Appendix I species bred in captivity or artificially propagated for commercial purposes *** For pre-Convention specimens					
13. This permit/certificate is issued by:					
Place		Date		Security stamp, signature and official seal	
14. Export endorsement		15. Bill of Lading/Air waybill number			
Block	Quantity				
A					
B					
C					
D		Port of export	Date	Signature	Official stamp and title

CITES PERMIT/CERTIFICATE No.

# Bos gaurus (B. frontalis) - Энэтхэгийн Бизон үхэр Bos javanicus - Бантенг үхэр

## Gaur( Энэтхэгийн Бизон үхэр)

**Бусад нэрс:** Селаданг (Малайз), Поиунг (Бирм)

**Тархалт:** Бангладеш, Бутан, Камбож, Энэтхэг, Лаос, Малайз, Бирм, Тайланд, Вьетнам

**Гадаад төрх:** Сэрвээний өндөр: 165-220 см, Их биеийн урт: 250-330 см, Сүүлний урт: 70-150 см, Жин: 650-1,000 кг

## Banteng(Бантенг үхэр)

Цайнэ (Бирм)

Камбож, Индонейз, Лаос, Малайз, Бирм, Тайланд, Вьетнам

Сэрвээний өндөр: 120-190 см, Их биеийн урт: 180-225 см, Сүүлний урт: 65-70 см, Жин: 400-900 кг

Олон улсад хамгаалагдсан байдал:\*

Энэтхэгийн бизон үхэр: **САЙТИС I Хавсралт**

ДБХХ-ны Улаан данс: Энэтхэгийн бизон үхэр **ЭМ** ангилал, Бантенг **Х** ангилал

**Монгол улсад хамгаалагдсан байдал:**

Амьтны тухай хууль, 2012


Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад

худалдааг зохицуулах тухай хууль, 2002


Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002

### Онцлох төрх:


Энэтхэгийн Бизон үхэр-*Bos gaurus* (*B. frontalis*)



Бие нь гүн хүрэн, хар эсвэл саарал. Хөлийн доод хэсэг цагаан.




Уруугаа хавтгай  
Хотгор гавал  
Эврийн урт: ≤95 см  
Эврийн тойрог: ≤56 см



Зургийг: Claire Beasly

Бантенг үхэр-*Bos javanicus*



Эрийн бие нь хар хүрнээс хар, эмийн бие нь цайвар хүрэн. Хөлийн доод хэсэг болон ууц цайвар.



Угтаа тойрог

Үсгүй, ясархаг




Залуу эр бантенг  
Зургийг: Марк Аулия/TSEA

Эврийн урт: ≤87 см  
Эврийн тойрог: ≤48 см

### Төстэй зүйл:

Одос үхэр-*Bubalus arnee*




Хөндий



Хавтгай


Эврийн урт: ≤149 см  
Эврийн тойрог: ≤58 см

Гаршуулсан үхэр-*Bos taurus*



Хавтгай

Такин-*Budorcas taxicolor*  
**САЙТИС II Хавсралт**




Эвэр нь угтаа биржгэр

Эврийн урт: ≤63.5 см  
Эврийн тойрог: ≤33 см



Худалдаанд: Эвэр болон гавлын яс, мах



Худалдаалагдаж буй эврүүд: А. Бантег Б. Энэтхэг Бизон  
Зургийг: TRAFFIC SEA



Худалдаалагдаж буй бантенгийн эвэр  
Зургийг: TRAFFIC SEA

Худалдаалагдаж буй Энэтхэгийн Бизоны эвэр  
Зургийг: TRAFFIC SEA



# Capricornis spp. – Хөхвөр гөрөөс

## Serow

**Бусад нэрс:** Камбинг Гурун (Малайз), Тав сай (Бирм)

**Тархалт:** Бангладеш, Бутан, Камбож Хятад, Энэтхэг, Индонез (Суматра), Япон, Лаос, Малайз, Бирм, Непал, Тайван, Тайланд, Вьетнам

**Гадаад төрх** Их биеийн урт: 140-155 см, Сэрвээний өндөр: 85-94 см, сүүлний урт: 11-16 см, Эврийн урт: 15-25.5 см

### Олон улсад хамгаалагдсан байдал:\*

Capricornis-ийн бүх зүйлүүд:

**САЙТИС I Хавсралтад** орсон (*C. crispus* – Япон серов гөрөөс болон *C. swinhoei*-аас бусад).

**ДБХХ-ны Улаан данс:** ЭЛ-ээс ЭМ ангилал (бүх зүйл жагсаалтад ороогүй)

### Монгол улсад хамгаалагдсан байдал:

Амьтны тухай хууль, 2012

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 2002

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002



Зургийг: Клайр Бисталл

### Онцлох төрх:



Зургийг: Клайр Бисталл



Зургийг: Клайр Бисталл



Зургийг: Крис Шеферд/TSEA

2 нүднийхээ дор тод булчирхайтай

- Урт чихтэй
- Богино хүзүүтэй, зулайнаас мөр хүртэл өтгөн зогдортой (хүрэн эсвэл цайвар өнгөтэй)
- Шируун, олон өнгийн үстэй: хүрэн-сааралдуу-хар, улаавтар
- Хэвлийгээрээ цайвар

### Төстэй зүйл:

#### Горал ямааны зүйл Naemorhedus spp.

Бүх зүйл нь **САЙТИС I Хавсралтад** орсон

Толгой биеийн урт: 82-130 см


Цээжний өндөр: 57-78.5 см

Сүүлний урт: 7-20 см

Эврийн урт: 7.8-12 см

- Capricornis-ийн зүйлийн амьтдыг бодвол жижиг биетэй
- Нүднийхээ доор булчирхайгүй
- Биеийн өнгө: хар саарал эсвэл улаан хүрэн өнгөтэй
- Ихэвчлэн хэвлий нь саарал өнгөтэй

Тархалт: Бутан, Хятад, Энэтхэг, Бирм, Солонгос, Лаос, Непал, Пакистан, Орос, Тайланд



Цагаан толбо

Урд хөлдөө цагаан судалтай

Нурууны гол хэсгээ дагасан хар судалтай

### Худалдаанд: Ихэвчлэн биеийн хэсгүүд (эвэр, толгой, урд хөл г.м)-ийг эмийн болон махны чиглэлээр ашигладаг.



Хөхвөр гөрөөсний эвэр

Зургийг: Крис Шеферд/TSEA



Хөхвөр гөрөөсний эвэр

Зургийг: Крис Шеферд/TSEA



Толгой, эврээс нь тос гарган авч буй байдал

Зургийг: Крис Шеферд/TSEA



Хөхвөр гөрөөсний арьс

Зургийг: Крис Шеферд/TSEA



Хөхвөр гөрөөсний толгой

Зургийг: Крис Шеферд/TSEA



Толгой, эврээс нь тос гарган авч буй байдал

Зургийг: Крис Шеферд/TSEA



# Pantholops hodgsonii – Түвд гөрөөс

## Tibetan Antelope

**Бусад нэрс:** Чиру (Англи), Цод (Төвд), Занглингян (Хятад)

**Тархалт:** Хятад (Шанхай, Шинжан), Энэтхэг (Жамму - Кашмир)

**Гадаад төрх:** Сэрвээний өндөр: 85 см хүртэл, Жин: 40 кг хүртэл

Олон улсад хамгаалагдсан байдал:\*

**САЙТИС I Хавсралт**

**ДБХХ-ны Улаан данс: X**

**Монгол улсад хамгаалагдсан байдал:**

Амьтны тухай хууль, 2012

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад

худалдааг зохицуулах тухай хууль, 2002

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002

**Жич: Гадаад төрхийн талаар холбогдох мэргэжилтнээс тодруулж асуух хэрэгтэй.**



### Онцлогдох төрх:

Түвд гөрөөсний үс, ноосоор хийсэн бүтээгдхүүнийг ШАТҮҮШ гэдэг. Шатүүш ороолт/алчуур нь илүү зөөлөн, нимгэн мөн нягт багтай.

Худалдаачид үүнийг нь бөгжин дундуур оруулж харуулдаг.

- Ихэвчлэн хүрэндүү, хул өнгөтэй (гэвч янз бүрийн будганд оруулдаг). Цагаан өнгөтэй нь хамгийн үнэтэй байдаг.
- Нэхмэлч нь өөрийнхөө нэрийг алчуур/ороолтын өнцөг дээр нь хадаж өгдөг
- Нэлэнхүйд нь эсвэл зөвхөн буланд нь тансаг уран хатгамалаар чимсэн байдаг
- Алчуур/ороолтын үзүүр нь богино цацагтай байдаг
- Янз бүрийн ромбо хэлбэртэй нарийн сүлжмэлтэй (томруулдаг шилээр харах боломжтой)




Зургийг: АНУ-ийн Загас Зэрлэг амьтдын алба




Зургийг: АНУ-ийн Загас Зэрлэг амьтдын алба

Шатүүшийг ноолуураар хийдэг бөгөөд урт үс байдаггүй. Хүний үснээс харьцангуй ширүүн бөгөөд буржийж, атиралдсан цөөн тооны богино, цайвар өнгөтэй "бүрхүүл үс" харагддаг.



Зургийг: Дэлхий Байгаль Хамгаалах Сан, Хятад улс



Зөвхөн эрэгчин нь маш өвөрмөц эвэртэй

Зургийг: Канадын хүрээлэн буй орчин

**Худалдаанд:** Арьс болон боловсруулсан алчуур/ороолт. Ихэвчлэн эвэр (мөн эмийн чиглэлээр хэрэглэдэг).



Хураагдсан Шатүүшин алчуур/ороолт

Зургийг: NRECD, Тайланд



Чимэглэсэн Чирүүгийн гавлын яс болон эвэр

Зургийг: Дэлхий Байгаль Хамгаалах Сан, Хятад улс

### Төстэй зүйл:

- Ямааны ноолуураар хийсэн Пашминатай адилхан харагддаг. Пашмина нь Шантүүшийг бодвол маш хямдхан.
- Шатүүштай адилхан харагддаг: хөнгөхөн, зөөлөн, зарим тохиолдолд ромбо хэлбэрийн сүлжмэлтэй, зарим тохиолдолд байхгүй. Сул сүлжсэн алчуур/ороолт нь утас/даавуун материал багтай учир бөгжин дундуур гарч болдог
- Уламжлал ёсоор пашмина алчуур/ороолт дээрхи цацаг нь урт мөн ихэвчлэн мушгиа хэлбэртэй байдаг.



Зургийг: АНУ-ийн Загас Зэрлэг амьтдын алба



Зургийг: АНУ-ийн Загас Зэрлэг амьтдын алба

# Saiga tatarica - Монгол бөхөн

## Saiga Antelope

**Бусад нэрс:** Монгол бөхөн, Соргог бөхөн

**Тархалт:** Казахстан, Монгол, Орос, Туркменистан, Узбекистан

**Гадаад төрх:** Их биеийн урт: 108-146 см, Сүүлний урт: 6-13 см, Жин: 21-51 кг


**Олон улсад хамгаалагдсан байдал:**\*

**САЙТИС II Хавсралт**

**ДБХХ-ны Улаан данс: НХ**

**Монгол улсад хамгаалагдсан байдал:**

Амьтны тухай хууль (2012)-ийн 1 дүгээр хавсралтад нэн ховор, 1930 оноос агнахыг хуулиар хориглосон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 2002 Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002



Зургийг: Канадын Хүрээлэн Буй Орчин

### Бөхөнгийн эврийн хэлбэр:



Зургийг: TRAFFIC SEA

Ямар ч эвэрнээс онцлог.

Зөвхөн эрэгчин нь эвэртэй байх ба эвэр нь:

- Угтаа цул
- Хагас тунгалаг
- Цайвар лав саарал өнгөтэй
- Хөндлөн огтлол нь тойрогдуу хэлбэртэй
- Бага зэрэг мурийсан
- Уртаараа 30 см хүрдэг (муруйн хамт)



Зургийг: TRAFFIC SEA



30 см  
хүртэл



Зургийг: Канадын Хүрээлэн Буй Орчин



Худалдаалагдаж буй бөхөнгийн эвэр  
Зургийг: TRAFFIC SEA



Зургийг: TRAFFIC SEA



Зургийг: TRAFFIC SEA




Хусааж огтолсон эвэр  
Зургийг: Клер Бисталл



Зургийг: TRAFFIC SEA



Бөхөнгийн  
эврээс  
гаргаж авсан  
бүтээгдэхүүний  
жишээ  
Зургийг: TRAFFIC SEA



Уламжлалт эмийн савлагаан дээр бичсэн бөхөнгийн эврийн тайлбар.

Бөхөнгийн эвэр  
Хятад  
ханзаар: 羚羊角

Хөрвүүлбэл: Линг Яанг Жиао











# Буга болон бусад эвэрт амьтад

## Deer Antlers

Худалдаанд ихэвчлэн зарагддаг бугын болон бусад гөрөөсний эврүүд. Зөвхөн бие гүйцсэн эр амьтад эвэртэй. Тодорхой хугацаанд унаж, ургадаг (тугалмайтнаас ялгаатай).

Олон улсад хамгаалагдсан байдал\*:  
САЙТИС-д янз бүрээр бүртгэгдсэн.

<p><b>Тахир гөрөөс <i>Axis porcinus</i></b> ДБХХ-ны Улаан данс: Х, <i>Axis porcinus annamiticus</i> (Вьетнамаас) НХ гэж бүртгэгдсэн.</p>  <p>Их биеийн урт: 140-150 см Сүүлний урт: 17-21 см Сэрвээний өндөр: 65-72 см Жин: 70-110 кг Тархалт: Бангладеш, Камбож, Хятад, Энэтхэг, Бирм, Непал, Пакистан, Тайланд</p>	<p><b>Толбот буга <i>Cervus nippon</i></b> ДБХХ-ны Улаан данс: ЭЛ, <i>Cervus nippon pseudaxis</i> (Вьетнамаас) НХ гэж бүртгэгдсэн.</p>  <p>Их биеийн урт: 95-180 см Сүүлний урт: 7.5-15 см Сэрвээний өндөр: 65-110 см Жин: 80кг хүртэл Тархалт: Хятад, Япон, Орос, Тайван, Вьетнам</p>	<p><b>Барашинг буга <i>Rucervus (Cervus) duvaucelli</i></b> САЙТИС I Хавсралт ДБХХ-ны Улаан данс: Х</p>  <p>Ихэвчлэн 10-15 салаа эвэртэй <i>Rucervus eldi</i>-тэй адил жигд зөөлөн эвэртэй.</p> <p>Их биеийн урт: 180 см хүртэл Сүүлний урт: 12-20 см Сэрвээний өндөр: 119-124 см Жин: 81 кг хүртэл Тархалт: Энэтхэг, Непал</p>	<p><b>Худалдаанд: Бүтэн эвэр, цусан эвэр болон бусад зүйлсийг нь уламжлалт эмийн байдлаар</b></p>  <p>Зургийг: TRAFFIC Зүүн Өмнөд Ази</p>
<p><b>Элдийн гөрөөс <i>Rucervus (Cervus) eldii</i></b> САЙТИС I Хавсралт ДБХХ-ны Улаан данс: Х</p>  <p>Их биеийн урт: 150-170 см Сүүлний урт: 22-50 см Сэрвээний өндөр: 120-130 см Жин: 95-150 кг Тархалт: Камбож, Энэтхэг, Лаос, Бирм, Тайланд, Вьетнам</p>	<p><b>Самбар буга <i>Rusa (Cervus) unicolor</i></b> ДБХХ-ны Улаан данс: ЭМ</p>  <p>Их биеийн урт: 170-270 см Сүүлний урт: 22-35 см Сэрвээний өндөр: 120-150 см Жин: 150-300 кг Тархалт: Камбож, Хятад, Энэтхэг, Индонез, Лаос, Малайз, Бирм, Филиппини, Шри Ланка, Тайланд, Вьетнам</p>	<p><b>Ява арлын буга <i>Cervus timorensis</i></b> ДБХХ-ны Улаан данс: ЭЛ</p>  <p>Их биеийн урт: 130-210 см Сүүлний урт: 10-30 см Сэрвээний өндөр: 80-110 см Жин: 50-115 кг Тархалт: Индонез</p>	 <p>Зургийг: TRAFFIC Зүүн Өмнөд Ази</p>



# Moschus spp. – Хүдэр (Баданга хүдэр)

## Musk Deer spp.

**Бусад нэрс:** Кадо Гав (Бирм)

**Тархалт:** Афганистан, Бутан, Хятад, Энэтхэг, Солонгос (Өмнөд, Хойд), Лаос, Монгол, Бирм, Непал, Пакистан, Орос, Вьетнам

**Гадаад төрх:** Их биеийн урт: 70-100 см, Сэрвээний өндөр: 50-61 см, Сүүлний урт: 1.8-6 см, Жин: 7-17 кг

**Олон улсад хамгаалагдсан байдал\*:**

**САЙТИС I Хавсралт:** Афганистан, Бутан, Энэтхэг, Бирм, Непал болон Пакистаны хүдэр

**САЙТИС II Хавсралт:** Баданга хүдэр болон бусад хүдрийн бүх зүйлүүд хүдэр тархсан бүх газарт

**ДБХХ-ны Улаан данс:** Баданга хүдэр ЭМ, бусад нь зүйлээс хамаарч ЭЛ эсвэл Х

**Монгол улсад хамгаалагдсан байдал:**

Амьтны тухай хууль (2012)-ийн 1 дүгээр хавсралтад нэн ховор,

1953 оноос агнахыг хуулиар хориглосон

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 2002

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002



**Онцлог шинж:**



- Эвэргүй
- Хондлой нь сэрвээнээс 5см орчим өндөр
- Их бие нь өтгөн өрвийж боссон нягт үсээр хучигдсан ба суурь нь голдуу цагаан байдаг
- Зүс: янз бүр бөгөөд голдуу бараан хүрэн, нуруун хэсэгтээ цайвар эрээн толботой, хэвлий хэсэгтээ бараан
- Эрүү чихний дотоод хүрээ, гуяны дотоод хэсэг цайвар, төвөнхийн 2 талаар цагаавтар толбонуудтай байж болно

Гирээгийн дээд соёонууд 7.5см урт харин гирэгчингийнх арай богино.



Зургийг: WWF-Канон/Григори МАЗМАНЬЯН

**Худалдаанд:** Баданга хүдрийн заарыг ардын эмнэлэгт өвчин намдаах зориулалтаар бүтнээр нь эсвэл тос, цацагч, наалт болон нунтаг хэлбэрээр худалдаалдаг.

**Заарын булчирхай**

Зургийг: TRAFFIC



**Хүдрийн заарын булчирхай:**

- 3-аас дээш настай гэрээгийн төмсөг хүй хоёрын хооронд байрлана.
- Голдуу 4-6см урт, 3.5-4.5см өргөн, 4-5см зузаан булчирхайг худалдаалдаг.
- Тухайн амьтнаас булчирхайг огтолж аваад хатаадаг.
- Доторх булчирхай нь хатаад улаан хүрнээс хар өнгөтэй нунтаг болдог.

**Хүдрийн заарын савласан жишээнүүд**

Зургийг: TRAFFIC



Уламжлалт эмийн бүтээгдэхүүн дээр хүдрийг тайлбарласан бичээс

	Баданга хүдэр	Заар
Хятад ханз:	鹿麝	麝香
Чинь:	Лу Шэ	Шэ Шян
Ром:	Москус, Керви	Москус

# Felidae (1) – Мийн овог

## Cats

**Гадаад төрх:** Их биеийн урт: 37-280 см  
Сүүлний урт: 5.1-110 см  
Жин: 1.5-306 кг

**Олон улсад хамгаалагдсан байдал\*:**  
Мийн овгийнхон (тэжээвэр муурнаас бусад)  
**САЙТИС I, II хавсралтад** орсон

**Монгол улсад хамгаалагдсан байдал:**  
Амьтны тухай хууль (2012)-ийн 1 дүгээр хавсралтад нэн ховор,  
1972 оноос агнахыг хуулиар хориглосон  
Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 2002  
Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио  
цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002



Леопард ирвэсийн зулзага  
Зургийг: WWF- Канон/Алайн КОМПОСТ

### Онцлог шинж:



Леопард ирвэс  
Зургийг: WWF- Канон/Алайн КОМПОСТ

Толгой: богино, дугуйрсан  
Их бие: уян хатан, булчинлаг, нягт, өргөн мөртэй  
Хөх: 2-4  
Хөл: Урд савар 5 салаа, Хойд савар 4 салаа хуруутай, ул нь үсгүй



**Хумс:**  
Урж тастахад  
зохилдсон

**Хэл:**  
Урж тастахад  
зохилдсон



Бар  
Зургийг: крис Шеферд/TSEA



Азийн шаргал муур  
Зургийг: WWF- Канон/  
Жералд С.Куббит


Чих: үзүүртэй эсвэл дугираг

Нүд: хүүхэн хараа нь босоо



Ширэнгийн зэрлэг муур  
Зургийг: WWF- Канон/  
Рожер ХУПЕР

### Толгойн яс:



Мийн овгийнхний толгойн  
яс дугуйрсан ба 28-30  
богино шүдтэй



Барын *Panthera tigris* толгойн яс  
Зургийг: Крис Шеферд/TSEA



Нохдын овгийнхны толгойн яс  
Уртассан 32 шүдтэй



Сиветийн овгийнхны толгойн яс  
Урт, хавтгайрсан 32-40 шүдтэй




Баавгайн овгийнхны толгойн яс  
Мантгар, бат бөх  
40-42 шүдтэй

Зургийг: Тим Лаулер



Суусрын овгийнхны толгойн яс  
богино нүүртэй  
28-38 шүдтэй

### Шүд:



- А. Үүдэн шүд: жижиг ба нэг шугаманд (дээрээ 3, доороо 3) x 2
- Б. Соёо: урт, хурц, бага зэрэг муруй (дээрээ 1, доороо 1) x 2
- В. Таслах (арааны өмнөх) шүд: том (дээрээ 2-3, доороо 2) x 2
- Г. Бутлах шүд (араа): дээд-жижиг (дээрээ 1, доороо 1) x 2

Зургийг: Тим Лаулер

### Худалдаанд:

Арьс, яс, мах, шүд, сарвуу, хумс  
ардын эмнэлэгт зарим хэсгийг нь,  
мөн амьдаар нь



# Felidae (2) САЙТИС I Хавсралтад бүртгэгдсэн Зүүн өмнөд Азийн мийн овгийнхон

## Southeast Asian cats listed in САЙТИС I Хавсралтад бүртгэгдсэн Зүүн өмнөд Азийн мийн овгийнхон

### Монгол улсад хамгаалагдсан байдал:

Амьтны тухай хууль (2012)-ийн 1 дүгээр хавсралтад нэн ховор,

1972 оноос агнахыг хуулиар хориглосон

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 2002

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002



Зургийг: Крис Шеферд/TSEA

#### Бар *Panthera tigris*



Зургийг: WWF-Канон/Майк ГРИФФИТ

Их биеийн урт:  
140-180 см  
Сүүлний урт: 60-95 см  
Жин: 180-245 кг



Зургийг: Жулиа Нг/TSEA

#### Цоохор ирвэс *Panthera uncia*



Зургийг: WWF-Канон/Мартин ХАРВЕЙ

Их биеийн урт: 100-130 см  
Сүүлний урт: 80-100 см  
Жин: 30-55 кг

Үсний урт нь Зүүн Өмнөд Азийн  
бусад мийн зүйлүүдээс урт,  
хэвлий хэсгээрээ нягт



Зургийг: Крис Шеферд/TSEA

#### Азийн шаргал муур *Catopuma temminckii*



Зургийг: WWF-Канон/Жералд С.КУББИТ

- Арьсан бүрхүүл нь жигд
- Арьсны өнгө нь янз бүр (шаргал бороос цайвар бор, бараан саарлаас хар)
- Нурууны дагуу бараан харин хэвлий зөвхий саарал
- Сүүлэн дээгүүрээ бараан, доогуураа зөвхий цайвар ба бараан үзүүртэй

Тэмдэглэл: Мянмарын зарим бодгалиуд их хэмжээний бараан толбо болон судалтай. Харин нүүр болон сүүл нь ердийн зүйлүүдтэй адил.

Толгой биеийн урт:  
76-84 см  
Сүүлний урт: 43-50 см  
Жин: 12-15 кг

#### Бидэрт муур *Pardofelis marmorata*



Зургийг: WWF-Малайз/Кен СКРИВЕН

- Маш нягт үстэй
- *Neofelis nebulosa*-тай адил боловч жижиг, хөл нь хар толбоор илүү хучигдсан.

Толгой биеийн урт:  
45-53 см  
Сүүлний урт: 47-55 см  
Жин: 2-4 кг

#### Леопард ирвэс *Panthera pardus*



Зургийг: WWF-Канон/Жералд С.КУББИТ

Их биеийн урт:  
91-191 см  
Сүүлний урт: 45-78 см  
Жин: 45-65 кг

Зарим газраас хар үстэй леопард ирвэс олддог – (толбо нь нарны гэрэлд харагдана).



Зургийг: SEA

Зургийг: WWF-Канон/Мартин ХАРВЕЙ

#### Үүлэн толбот ирвэс *Neofelis nebulosa*



Зургийг: WWF-Канон/Жералд С.КУББИТ

Их биеийн урт: 61-106 см  
Сүүлний урт: 55-91 см  
Жин: 15-23 кг



Зургийг: Крис Шеферд/TSEA

Зургийг: WWF-Канон/Жералд С.КУББИТ

#### Хавтгай толгойт муур *Prionailurus planiceps*



Зургийг: Клейр Бисталл

- Чих жижиг, толгойн орой хэсэг уртассан мөн хавтгайрсан
- Үсэн бүрхүүл нь гүн улаан. Биеийн дээд хэсгийн үс нь хүрэн бор гүн саарал ба хүрэн шаргал бидэртэй

Толгой биеийн урт:  
44-50 см  
Сүүлний урт: 13-17 см  
Жин: 1.5-2.2 кг

#### Леопард муур *Prionailurus bengalensis*



Зургийг: WWF-Малайз/Е.П.Жий

- Улаан шаргал эсвэл шаравтар өнгийн зүстэй, сүүл биеийн дээд хэсэг нь хар толботой. Биеийн доод хэсэг нь цайвар ба хар толботой
- *Prionailurus viverrinus*-Загасч мууртай (толгой биеийн урт 72-78см) төстэй боловч биеэр жижиг

Толгой биеийн урт: 40-55 см  
Сүүлний урт: 23-29 см  
Жин: 3-5 кг

Тэмдэглэл: Зөвхөн Бангладеш, Энэтхэг болон Тайландад байдаг популяциуд нь САЙТИС I Хавсралтад бүртгэгдсэн. Бусад бүх популяциуд нь САЙТИС II Хавсралтад бүртгэгдсэн.



# Felidae (3) (Мийн овгийнхон)-Түгээмэл худалдаалагддаг биеийн хэсэг ба дайвар эрхтнүүд

## Felidae (Cats)- Parts and Derivatives commonly found in Trade

**Худалдаалах хэлбэр:** яс, мах, шүд, хумсыг нь уламжлалт эмнэлэгийн хэрэгцээнд (арьсыг нь нарийн тодорхойлох аргийг САЙТИС-ийн Зүүн өмнөд Азийн мийн овгийнхон хэсгээс харна уу).

**Олон улсад хамгаалагдсан байдал\*:**

Бүх муурнууд (тэжээвэр муурнаас бусад) **САЙТИС I, II хавсралтад** орсон

**Монгол улсад хамгаалагдсан байдал:**

Амьтны тухай хууль (2012)-ийн 1 дүгээр хавсралтад нэн ховор, 1972 оноос агнахыг хуулиар хориглосон

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 2002

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002



Леопард ирвэсийн зулзага  
Зургийг: WWF- Канон/Алайн

### Яс

БҮТЭН ЯСААР



Барын (*Panthera tigris*)

толгойн яс  
Зургийг: Крис Шеферд



Барын хураагдсан яс

Зургийг: Крис Шеферд

**Эсвэл уламжлалт эмнэлэгт эмийн орц болж ордог.**

Уламжлалт эмнэлэгийн савлагаан дээр барын яс болон леопард ирвэсийн ясыг тайлбарласан энгийн тайлбар

Барын ясаар хийж савласан бүтээгдэхүүн  
Зургийг: TRAFFIC



Хятад Ханз

Чины

Барын яс

虎骨

Ху Гу

Ирвэсийн яс

豹骨

Бао Гу

### Шүд

БАРЫН  
ЖИНХЭНЭ ШҮД

БАРЫН ХУУРАМЧ  
ШҮД

1 болон  
түүнээс  
дээш  
ховилтой

Титэм  
(аманд  
харагддаг  
хэсэг)

Соёоны  
ёзоор нь  
хуурайшсан  
тохиолдолд  
хагарамтгай  
болдог

Ёзоор  
(буйланд  
далд  
байдаг  
хэсэг)

Барын шүд-жинхэнэ ба хуурамч

Зургийг: Крис Шеферд



Шүдээр сийлбэр хийсэн байж болно  
Зургийг: Крис Шеферд



Арьс нь жинхэнэ, шүд нь хуурамч. Жинхэнэ шүдийг тусад нь зарсан байж болзошгүй.  
Зургийг: Крис Шеферд

### Хумс

Тал тойрог үүсгэнэ  
Өнгө нь шаргал/цайвар

Тунгалаг байж болно  
Ясан төгсгөлд нь тод харагдах бүтэцтэй



Зургийг: USFWS

Ясан төгсгөлд нь тод харагдах бүтэцтэй

### Бэлэг эрхтэн

Барын бэлэг эрхтэн хуурамч байх тохиолдлууд:

1. Үзүүр хэсэгт мэдэгдэхүйц өргөстэй
2. Рентген туяанд бэлэг эрхтний яс харагдана
3. 20 см-ээс урт



Барын бэлэг эрхтэн  
Зургийг: К. Бисталл

Барын жинхэнэ бэлэг эрхтэнд өргөс бараг харагдахгүй



Дөнгөж агнагдсан леопард ирвэсийн бэлэг эрхтэн  
Зургийг: Леонг/TSEA

Барын хуурамч бэлэг эрхтэн  
Зургийг: Леонг/TSEA



# Зүүн өмнөд Азийн халиу

## Southeast Asian Otters

**Бусад нэрс:** Мемеранг (Малайз)  
**Гадаад төрх:** Хүрэн, цайвар хоолой, нягт үс, урт гуалиг биетэй, торлог хуруунууд, булчинлаг сүүлтэй  
 Толгой биеийн урт: 36-80 см.  
 Сүүлний урт: 22.5-48 см

### Онцлог шинж:

**Азийн жижиг сарвуут халиу**  
*Aonyx cinerea*  
**САЙТИС II Хавсралт**  
 ДБХХ-ны Улаан данс: ЭМ

Их биеийн урт: 36-55 см  
 Сүүлний урт: 25-35 см

- Бие жижиг
- Бараан хүрнээс саарал хүрэн
- Хоолой болон хүзүүний хоёр тал цайвар
- Сарвуу жижиг, хөлийн сарвуунаас илүү гарахгүй



Зургийг: Жералд С. КУТБИТТ/WWF-Канон

Тархалт: Ази – Зүүн өмнөд Азид: Бруней Даруссалам, Камбож, Индонез, Лаос, Малайз, Бирм, Филиппин, Сингапур, Тайланд, Вьетнам

**Голын халиу**  
*Lutra lutra*  
**САЙТИС II Хавсралт**  
 ДБХХ-ны Улаан данс: УБ

Их биеийн урт: 55-72 см  
 Сүүлний урт: 37.5-48 см

- Нүцгэн хамар болон нүүрэн дэхь арьсны хооронд W хэлбэрт ирмэгтэй
- Богино ноолуур урт цайвар үстэй холилдон буурал зүстэй харагддаг
- Сүүлний уг дугариг



Зургийг: Шанчез болон Лопез/WWF-Канон

Тархалт: Европ болон Ази.  
 Зүүн өмнөд Ази: Камбож, Индонез, Лаос, Бирм, Тайланд, Вьетнам

### Олон улсад хамгаалагдсан байдал\*:

Халиуны багийн бүх зүйлүүд **САЙТИС II Хавсралтад** бүртгэгдсэн, зөвхөн Голын халиу **САЙТИС I Хавсралтад** бүртгэгдсэн,

### Монгол улсад хамгаалагдсан байдал:

Амьтны тухай хууль (2012)-ийн 1 дүгээр хавсралтад нэн ховор, 1930 оноос агнахыг хуулиар хориглосон  
 Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, 2002  
 Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, 2002

**Суматра арлын халиу**  
*Lutra sumatrana*  
**САЙТИС II Хавсралт**  
 ДБХХ-ны Улаан данс: Х

Их биеийн урт: 50-80 см  
 Сүүлний урт: 37-50 см

- Биеийн дээд хэсэг болон хүзүүний хоёр тал бараан хүрэн
- Эрүү, хоолойноо жигд бус толботой
- Сүүлний уг дугариг
- Хамрын үзүүр нь үсээр хучигдсан



Зургийг: Аннет Олссон/CI Камбож

Тархалт: Камбож, Малайз, Тайланд, Вьетнам

**Гөлгөр нөмрөгт халиу**  
*Lutra perspicillata*  
**САЙТИС II Хавсралт**  
 ДБХХ-ны Улаан данс: ЭМ

Их биеийн урт: 65-75 см  
 Сүүлний урт: 40-45 см

- Арьс гөлгөр, гялгар
- Хоолой ба хүзүүний хоёр тал цайвар
- Нүүрний үс болон нүцгэн хамрын дунд шулуун зураастай
- Сүүлний уг бага зэрэг хавтгайрсан



Зургийг: Клейр Бисталл

